

ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

1.1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаархи мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 2 удаа хийж ИТХ-ын Тэргүүлэгчид, ажлын албаны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай, Аймгийн Цагдаагийн газрын тайлан, Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн тайлан, 2018 онд аймгийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээ байршил зориулалтыг батлах тухай, Ажлын хэсэг томилж ажиллуулах тухай, 2018 оны төсвийн тодотгол батлах тухай,Төрийн шагналд уламжлах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэж тогтоолыг гаргаж биелэлтийг хангуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажиллаж байна.

Аймгийн ИТХ-аас сумдын ИТХ-ын үйл ажиллагаанд, болон аймгийн ИТХ-ын шийдвэрийн хэрэгжилтийг нутгийн захиргааны байгууллагууд хэрхэн зохион байгуулж байгаад хяналт шинжилгээ үнэлгээ хийх удирдамжийг боловсруулан батлуулж ажлын хэсэг томилогдон сумдын Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үйл ажиллагааны явц, холбогдох хуулинд заагдсан эрх үүргийн болон дэвшүүлсэн бодлого зорилтын биелэлт, аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс гаргасан сумуудтай холбоотой шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, зөрчлийг арилгуулах, арга зүйн зөвлөгөө удирдлагаар хангах ажлыг Цагаанхайрхан, Цагаанчулуут, Отгон, Шилүүстэй, Алдархаан, Нөмрөг, Баянхайрхан, Асгат, Тэс Баянтэс сумдад зохион байгуулж ажиллаа.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2017 онд хийсэн ажлын танилцуулгыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулж, 2018 онд хийх ажлын төлөвлөгөөний саналыг нэгтгэн, аймгийн ГХУСАЗСЗ-ийн хурал хуралдаж 2017 оны хийсэн ажлын гүйцэтгэл, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэж батласан.

Мөн аймгийн ГХУСАЗСЗ, "Алтан гадас" одонт Цагдаагийн газар, аймгийн Прокурорын газар, Баянтэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газартай хамтран Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын хүрээнд 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Хойд бүсийн сумдын дунд "ХОРТ ЗУРШЛЫН ЭСРЭГ ХАМТДАА" арга хэмжээг зохион байгуулсан.

1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаархи мэдээлэл:

Аймгийн Засаг даргын ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Хамтын хүч-хөгжлийн гарц” эмэгтэйчүүдийн чуулган, үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 24 сумын бизнес эрхлэгч эмэгтэйчүүд оролцож, өөрсдийн гараар урласан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнээ иргэдэд сурталчилан, төгрөгний борлуулалт хийлээ.

Чуулганы үеэр Монголд анх удаа тэр тусмаа Завхан аймагт анх удаа Дэлхийн зөн олон улсын байгууллагын Францын талын санхүүжилтээр 2018-2022 он хүртэл хэрэгжих Европын холбооны эдийн засгийн төслийн нээлт боллоо.

Мөн Орхон аймагт энэ сарын 26-27-ны өдрүүдэд бизнес эрхлэгчдийн бүтээлийн үзэсгэлэн худалдааг гаргаж 17 сумын 34 бизнес эрхлэгчид хамрагдан 54,3 сая төгрөгний борлуулалтыг зах зээлд хийлээ.

Улсын онцгой комиссын даргын тушаалаар Монгол Улсын шадар сайд Ө.Энхтүвшин сайдаар ахлуулсан “Шуурхай бүлэг”-ийн 32 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Өвархангай аймгаас эхлэн Улсын хэмжээнд өвөлжилт хүндрэлтэй байгаа аймгуудад ажиллаж байгаа бөгөөд Завхан аймгийн Тосонцэнгэл суманд онцгой комиссыг 2018 оны 01 сарын 30, 31-ний өдрүүдэд хуралдуулан ажиллаа.

Аймгийн 2017 оны онцлог үйл ажиллагаа, Нүүдэлчдийн соёлын наадмын мэдээлэл бүхий 2018 оны ханын хуанлийг өрх бүрт хүргэхээр 2018 оны хуанлийг хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2017 оны ажлыг дүгнэх ажлын хэсэг томилогдон ажиллаж, дүнгээ нэгтгэж байна. Мөн сум, багийн 2017 оны ажлыг дүгнэх ажлын хэсэг гарч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөлөөс 2018 оны 01 сарын 18-ны өдөр Төрийн үйлчилгээний албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 6 сургуулийн захирал, 1 цэцэрлэгийн эрхлэгчийн орон тоон дээр 12 иргэн сонгон шалгаруулалтад оролцож, 7 иргэн тэнцэж, 1 сургуулийн захирал, 1 цэцэрлэгийн эрхлэгчийн орон тоон дээр шалгаруулалтад орсон иргэд тэнцсэнгүй.

Аймгийн Засаг дарга иргэдээ сонсдог, иргэндээ ээлтэй төр байх зарчмыг баримтлан 2018 оны 01-р сарын 02-ноос 01-р сарын 14-ны хооронд 24 суманд ард иргэдээ сонсох, төрийн ажлыг ард иргэдээр үнэлүүлэх, өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах, Засгийн газрын 01 албан даалгаврын хэрэгжилт, 2017 оны үндсэн чиглэлийн биелэлт зэрэг ажлын хүрээнд 5 чиглэлд 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаад ирсэн. Энэ үеэр сургалт болон ахмадууд эмэгтэйчүүдтэй уулзалт зохион байгуулаж, төрийн ажлыг иргэдээр үнэлүүлэх, хэрэглэгчийг үнэлгээг иргэдээр үнэлүүлэх ажлыг тус тус зохион байгуулсан.

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэнд 2018 оны 01-р сард 29 өргөдөл гомдол ирсэн. Үүнээс 17 өргөдөл гомдлын хариуг шийдвэрлэсэн.

2018 оны 01-р сарын 13-ны өдрөөс 01-р сарын 18-ны өдрийн хооронд Аймгийн Засаг дарга Д.Батсайхан тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-ын Бээжин, Шиан хотуудын аялал, жуулчлалын салбарын хөгжлийн туршлага судлах мөн "Нүүдэлчдийн соёлын наадам"-ыг сурталчлан гадаадын жуулчдыг оролцуулах зорилгоор аялал жуулчлалын компаниудын төлөөлөлтэй санал солилцох уулзалт хийлээ.

Мөн 2018 оны 01 сарын 16-ны өдөр Засаг даргын Зөвлөлийн ээлжит хурал хуралдаж, зөвлөлийн хурлаар 24 суманд ард иргэдээ сонсох, төрийн ажлыг ард иргэдээр үнэлүүлэх, өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах, Засгийн газрын 01 албан даалгаврын хэрэгжилт, 2017 оны үндсэн чиглэлийн биелэлт зэрэг ажлын хүрээнд 5 чиглэл рүү 12 хоногт ажлын хэсэг ажиллаад ирсэн ажлыг хэсгийн тайлан мэдээ үр дүнг хэлэлцсэн.

Монгол улсын цол, Төрийн дээд одон медалиар шагнагдахаар тодорхойлогдсон худалдаа, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, эдийн засаг, хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээл, идэвх санаачлагчтай ажилласан 75 иргэний материалыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 01 сарын 15, 19-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, тогтоол гаргуулан Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан. Үүнд: Монгол улсын гавьяат багш-2, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон-7, Алтан гадас одон-38, Хөдөлмөрийн хүндэт медаль-28.

Аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт нийт 2201 албан бичиг ирж, Үүнээс 261-н албан бичиг хугацаатай байна. Одоогийн байдлаар 11-н албан бичиг хугацаа нь болоогүй хүлээгдэж байна. Засаг даргын Тамгын газраас нийт 1769 албан бичигт дугаар олгосон байна. Хот болон аймаг сумын нийт 731 албан бичгийг Шуудан холбоогоор дамжуулан холбогдох газарт нь хүргүүлсэн. Байгууллагуудад эх хувиараа хүргэгдэх 673 албан бичгийг цаг алдалгүй хүргэж ажилласан.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

2.1.Төсвийн гүйцэтгэл: Аймгийн хэмжээгээр 2017 онд төсөвлөгдсөнөөр 63 тэрбум 887.5 сая төгрөг, зарлага 62 тэрбум 45.8 сая төгрөгт хүрсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 10.6 хувь буюу 5 тэрбум 968.6 сая төгрөгөөр өссөн байна.

Монгол банкны мэдээгээр оны эхнээс өссөн дүнгээр гүйлгээнд 4 тэрбум 889.4 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжинд 64.5 мянган иргэний 72.4 тэрбум төгрөг байгаа нь иргэдийн мөнгөн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 7.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Аймгийн дүнгээр 120.7 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 9.0 хувь буюу 10 тэрбум төгрөгөөр өссөн байна. Зээлийн сарын хүүг

арилжааны банкуудаар авч үзвэл дунджаар ХААН банк 1.82%, Хас банк 0.58-2.0%, Төрийн банк 1.66%, Капитал банк 1.5% байна.

2.2. Татвар төлөлтийн байдал: Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 128.8 хувийн биелэлттэй, 12 тэр бум 743.1 сая төгрөгийн орлого оруулсаны цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 42.2 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 3.9 хувь, ашигт малтмал ашигласаны төлбөр 20.4 хувь, бусад нэр төрөл 33.5 хувийг тус тус эзэлж байна. Нийт татварын орлогын бүрдүүлэлтийн 73.3 хувь буюу 9 тэрбум 337.7 сая төгрөгийг орон нутгийн орлого, 26.7 хувь буюу 3 тэр бум 405.4 сая төгрөгийг улсын төсвийн орлого бүрдүүлж байна.

Гурав. Хууль зүйн бодлогын хүрээнд:

3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа: Аймгийн хэмжээнд орон нутгийн замд зам тээврийн ослын хүний амь нас эрсдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2018 онд Зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, зохих дүгнэлт өгч, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн урт болон богино хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг Засаг даргын 2017.01.18-ны өдрийн А/12 захирамжаар байгуулан ажлын хэсгийн ахлагчаар Хууль эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Батдаваа ажиллаж байна. Уг ажлын хэсэг хуралдаж хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Мөн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2018 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан ажиллаж байна.

3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээлэл: Аймгийн хэмжээгээр 221 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 30.8 хувийг иргэдийн эрх чөлөө эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 40.3 хувь нь бусдын өмчлөлийн эсрэг гэмт хэрэг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэргийн тоо 38-аар буурсан байна.

Энэ онд гэмт хэргийн улмаас 25 хүн нас барж, 88 хүн гэмтэж 558.9 сая төгрөгийн хохирол учирсан байна. Оны эхнээс өссөн дүнгээр 7371 зөрчил илрүүлж, 639 хүн эрүүлжигдэн, 221 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчил 1750, эрүүлжигдсэн хүн 20, баривчлагдсан хүн 166-аар тус тус өссөн байна. Сумдын гэмт хэргийн гаралт Алдархаан 20, Тосонцэнгэл 35, Их-Уул 15, Тэлмэн 12, Улиастай 66 бүртгэгдсэн нь бусад сумдаас харьцангуй өндөр байгаа юм.

3.3. Архивын ажлын мэдээлэл: Төрийн архивын тасгийн 2018 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 2017 онд хөтлөгдөж дууссан баримт бичгийг хадгалах хугацаагаар ангилан төрөлжүүлж техник боловсруулалт хийлээ.

4 хөмрөгийн удирдлагын баримт бичгийг баримтын түвшинд тодорхойлон бичих, тоо бүртгэлийн програмд оруулах ажлын хүрээнд 1001 хуудас баримтаас 893 заалт, 2584 хүний нэр, 60 PDF файл үүсгэн эх баримтыг холболлоо.

Ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд 7 хөмрөг, 7 данс, 143 хадгаламжийн нэгжийн 5673 хуудас баримтыг сканердаж, 7 хөмрөг 7 дансны 143 хадгаламжийн нэгж, 5673 хуудас баримтыг photoshop програмд засварлалаа.

7 хөмрөгийн 143 хадгаламжийн нэгж баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийж, үдэж хавтаслан холбогдох акт үйлдэж, данс бүртгэлд оруулсан.

168 иргэний хүсэлтийг хүлээн авч 708 баримт шүүж, 167 хуулбар, 89 лавлагаа тодорхойлолт 78 олгож төрийн үйлчилгээ үзүүллээ.

3.4. Онцгой байдал: Онцгой байдлын газрын мэдээгээр 2017 онд нийт 151 удаагийн гамшиг ослын холбогдолтой дуудлага хүлээн авч ажилласан байна.

Үүнд: Объектын гал түймрийн 67, ой хээрийн түймэр 5, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл 2, автомашин эвдэрсэн 8, автомашин цас, шавар, усанд суусан 26, хүн, малын гоц халдварт 7, зам даваа хаагдсан 1, шар усны үер 6, химийн бодис алдагдсан 1, усны осол 3, газар хөдлөлт 2, төөрсөн сураггүй болсон 19, иргэдээс ирүүлсэн хүсэлттэй холбоотой 4 мэдээ тус тус хүлээж авч холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж давхардсан тоогоор 181 албан хаагч 86 техник гарч ажилласан байна.

Объектын гал түймрийн 67 удаагийн дуудлагаар нийт 196.3 сая төгрөгийн хохирол учирч, байгууллага, аж ахуй нэгж иргэний 499.5 сая төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан байна. Гамшиг ослоос 65 иргэний амь нас аварч, ослын улмаас 26 хүний амь эрсэдсэн байна.

Аймгийн Онцгой комиссын чиглэлээр: Аймгийн онцгой комиссыг цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан 3 удаа хуралдуулан Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч МУЗГ-ын 286 дугаар тогтоолоор батлагдсан зудыг үнэлэх шалгуур үзүүлэлтээр аймгийн 6 сум цагаан зудтай, 8 сум цагаан зудархуу байдалд шилжсэн, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц дууссантай холбогдуулан аймгийн онцгой комиссыг 2 удаа хуралдуулж Засаг дарга, Засаг даргын орлогчоор ахлуулсан 2 ажлын хэсэг өвөлжилт хүндэрсэн сумдад удирдамж гарган ажилласан.

Аймгийн аюулгүйн нөөцөд байгаа өвс тэжээлийн хуваарь гаргаж сумдад хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Онцгой комиссын гишүүд, хэлтэс агентлаг, аж ахуй нэгж байгууллагуудад сумдыг хариуцан ажиллах хуваарь гарган Засаг даргаар батлуулан малчдад туслах хөдөлгөөнийг өрнүүлээд байна.

Монгол улсын шадар сайдын 2018 оны 01 дүгээр сарын 18 –ны өдрийн ЗГ-2\39 тоот албан бичгээр ирүүлсэн үүргийг хэрэгжүүлэхээр онцгой комиссыг хуралдуулан Онцгой байдлын ерөнхий газраас шүлхий өвчинтэй тэмцэх загвар төлөвлөгөөг ашиглан ХХААГ, ЦГ, МХГ тай хамтран халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх аймгийн төлөвлөгөө боловсруулан Засаг даргаар батлуулан ажиллаж байна.

Мал амьтны гоц халдварт өвчний голомт бүхий аймгуудын чиглэлд шилжилт хөдөлгөөн хийлгэхгүй байх, хорио цээр, хязгаарлалт бүхий бүсээс гоц халдварт өвчний нөхцөл байдлын талаар мэдээлэл авч малчдыг мэдээллээр хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдад Засаг даргын албан бичиг хүргүүлэх, Их-Уул суманд ажиллаж байгаа постыг 2018 оны 02 дугаар сарын 06-аас цааш хэдэн сар үргэлжлүүлэх хугацаа, зардлын тооцоо гаргаж танилцуулах талаар ХХААГ газарт үүрэг чиглэл хүргүүлэн ажиллаж байна.

Орон нутгийн өвөлжилтийн нөхцөл байдлын талаар: Аймгийн хэмжээнд 2017-2018 оны өвөл, хаврын улиралд 24 сумын 115 багийн 8.3 мянган малчин өрх, нийтдээ 5.7 мянган цэгт 3.6 сая мал, хонин толгойд шилжүүлснээр 5,8 сая мал өвөлжиж байна.

Үүнээс: Гадна 7 аймгийн 24 сумын нутагт 115 өрхийн 271 хүн, 71667 мал, Үндсэн сумынхаа нутагт 7,6 мянган өрхийн 3,0 сая орчим мал, Аймаг дотроо бусад сумын нутагт 303 өрхийн 365,0 мянган мал, Хилийн зурваст 120 өрхийн 71.0 мянган мал, Тусгай хамгаалалтай бүс нутагт 55 өрхийн 12.1 мянган мал аймаг дундын отрын бүсэд 4 сумаас 62 өрхийн 174 хүн, 74.2 мянган мал тус тус өвөлжиж байна.

Аймгийн Онцгой комиссоос Аймаг, сумдын өвс тэжээлийн аюулгүй нөөцийн хуваарь гарган Засаг даргаар батлуулан малчдад хүргэх ажлыг зохион байгуулж байна. Орон нутагт хаагдсан зам даваа онгойлгох, далпуу татах, малчны хотонд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, малчдад тусламж үзүүлэх хөдөлгөөн өрнүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч байна. 2017 оны 01 дүгээр сарын 23-ны байдлаар малын хорогдол 18.1 мянган толгой мал хорогдсон мэдээтэй байна.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

4.1. Боловсрол, соёлын чиглэлээр: 2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 30 сургуулийн 587 бүлэгт **14662** хүүхэд суралцаж байна. Үүнээс бага боловсролд 7454, суурь боловсролд 4608, бүрэн дунд боловсролд 2600 хүүхэд байна.

Хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид 1451 хүүхэд, 9 дүгээр ангид 1118 хүүхэд, 12 дугаар ангид 1242 хүүхэд элсэн суралцаж байна.

Ерөнхий боловсролын сургуулиудад аймгийн дүнгээр 1621 багш, ажиллагсад байгаагийн 55.1 хувь нь буюу **894** нь үндсэн багш, үүнээс 16.1 хувь нь магистр, 73.9 хувь нь бакалавр, 7.9 хувь нь дипломын боловсролтой багш нар ажиллаж байна.

Дотуур байранд 1390 хүүхэд амьдарч байгаагийн 74.0 хувийг нь малчдын хүүхэд эзэлж байна.

2017-2018 оны хичээлийн жилд төрийн өмчийн 36, хувийн өмчийн 3 нийт 39 цэцэрлэг ажиллаж, сургуулийн өмнөх боловсролд 6458 хүүхэд суралцаж байгаагаас цэцэрлэгийн үндсэн бүлэгт 5389 хүүхэд, хувилбарт сургалтанд 1069 хүүхэд суралцаж байна.

“Сайн багш”, “Сайн оюутан”, “Боловсрол, соёл урлагийн салбарыг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэлэлцүүлж байна.

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, салбарын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх оновчтой арга замыг хамтран дэвшүүлж, сургуулийн өмнөх боловсролын тогтолцоог эрчимтэй, тогтвортой, хариуцлагатай, үр ашигтайгаар хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Тогтвортой хөгжил” сургуулийн өмнөх боловсролын үндэсний чуулган Улаанбаатар хотод 2018 оны 1 сарын 8-9 хооронд боллоо. Зөвлөгөөнд сургуулийн өмнөх боловсролын удирдах ажилтан багшийн төлөөлөл 18 хүн оролцлоо. Зөвлөгөөнөөр сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлт болон салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэчлэх чиглэлийг тодорхойлсон байна.

“Багшийн сэтгэл хүүхдэд-III” сургалтыг Тосонцэнгэл сумд 2018 оны 01 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд Боловсролын хүрээлэн, МУБИС, Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 113 дугаар сургуулийн багш нартай хамтран зохион байгууллаа.

Сургалтанд зүүн болон хойд бүсийн нийт 14 сургуулийн удирдах ажилтан, багш, эмч, дотуур байрын багш, жолооч зэрэг нийт 428 хүн хамрагдлаа.

Цэцэн-Уул, Яруу, Тэлмэн, Шилүүстэй, Алдархаан, Дөрвөлжин, Улиастай сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт 2018 оны 01 дүгээр сарын 24-26-ны өдөр зохион байгуулагдлаа.

Ерөнхий боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг тогтвортой нэмэгдүүлэх, үнэлгээний шинэчлэл, салбарын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх оновчтой арга замыг хамтран дэвшүүлэх, боловсролын салбарын эрх зүйн шинэчлэл, хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгааллын бодлогын чиглэл, боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зорилготой “Тогтвортой хөгжил” ерөнхий боловсролын зөвлөгөөн Ховд аймагт 2018 оны 01 дүгээр сарын 28-30-ны хугацаанд зохион

байгуулагдаж, зөвлөгөөнд БСУГ, ЕБС-ийн удирдах ажилтан, багш нарын төлөөлөл 40 хүн оролцлоо.

2017-2018 оны Боловсролын салбарын төсвийг сангийн яамны пластик программд оруулж, хуваарийг холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

Энэтхэгийн соёлын харилцааны зөвлөл, Монгол улсад суугаа Энэтхэгийн элчин сайд, Завхан аймгийн Засаг дарга Д.Батсайхан нарын дэмжлэгтэйгээр Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын 10 хүний бүрэлдэхүүнтэй уран бүтээлчид Энэтхэг улсад 2018 оны 001 дүгээр сарын 04-20-ны хугацаанд болсон “INTERNATIONAL DANSE&MUSIC FESTIVAL”-д Монгол улсаа төлөөлөн оролцоо.

4.2.Эрүүл мэнд, спортын чиглэлээр: Аймгийн хэмжээнд 2017 онд 1321 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 1329 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 92 (6.5%)-оор, амьд төрсөн хүүхэд мөн дүнгээр буурсан байна. Энэ онд ихэр төрөлтийн 16 тохиолдол, амьгүй төрөлтийн 8 тохиолдол бүртгэгдсэн байна. Нийт төрсөн эхчүүдийн 4.3 хувийг охидын төрөлт, 15.8 хувийг 35-аас дээш насны эмэгтэйчүүдийн төрөлт эзэлж, нийт төрөлтийн 22.8 хувь нь кесар хагалгаагаар төрсөн байна. Энэ оны 12 дугаар сард 99 эх амаржиж, 99 хүүхэд төрүүлсэн нь өмнөх сараас амаржсан эх 23 (18.9%)-аар, амьд төрсөн хүүхэд 21 (17.5%)-ээр буурсан байна.

Эрүүл мэндийн газар нь аймгийн Цагдаагийн газартай хамтран 2017 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа тайланг 7 сумын 884 иргэдэд тавьж, Завхан сонинд мэдээллээ бэлдэн гаргаж 500 ширхэгийг иргэдэд хүргэж “Хуулиа дээдлээ” 21 хоногийн аяны хүрээнд “Архи хүний биед нөлөөлөх нь” сэдвээр 200 иргэнд мэдээлэл хийлээ.

Ургамал, Завханмандал, Дөрвөлжин, Сантмаргаз, Цэцэн-уул, Сонгино, Баянтэс, Тэс зэрэг зудтай, зудархуу сумдын эмийн эргэлтийн сангуудад зайлшгүй шаардлагатай 10-27 нэр төрлийн эмийг хүргэж ажилласнаар эмийн санд тасалдаад байсан эм хангагдсан байна.

НҮБ-ын хүүхдийн сангийн хамтын ажиллагааны хүрээнд “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж эрүүл мэндийн салбарт “Олон нийтэд түшиглэсэн хүүхдийн өвчний цогц менежмент”-төслийг хэрэгжүүлж байна. Төслийн зорилтын хүрээнд хүүхдийн өвчний цогц менежмент сэдэвт сургалтыг 3 сумын 45 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зохион байгуулж гарын авлага матетриалаар хангалаа.

Аймгийн Засаг даргын санаачилгаар хэрэгжүүлж буй “Сайн багш” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан зүүн, хойд чиглэлийн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 450 багш нарт “Өсвөр үеийн эрүүл мэнд”, “Эрүүл мэндийн бүлгэм”, “Үдийн цай хөтөлбөр, хоол тэжээл”, “Архи хүний биед нөлөөлөх нь”, “Дэлгэцийн донтолт”, “Осол гэмтлийн өнөөгийн байдал”, “Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлс”, “Эрүүл

мэндийг дэмжигч байгууллага” сэдвээр сургалт хийж 6 төрлийн 400 ширхэг гарын авлага тараасан байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын чанарын хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, аюулгүй байдал эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах, зөвлөн туслах, магадлан итгэмжлэлийн бэлтгэл хангуулах чиг үүргийн дагуу зайн сургалтыг аймгийн 24 сумын 67 эмч, мэргэжилтэнд зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан байна.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАР

Аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 08 ны өдрийн 442 дугаар захирамжаар “ Биеийн тамир, спортын салбарын статистикийн улсын нэгдсэн тооллого” -ыг аймагт зохион байгуулах ажлын хэсгийн байгуулж нэгдсэн програмд шивэлтийг хийж байна. Урьдчилсан мэдээгээр аймгийн хэмжээнд Биеийн тамир,спортын чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн 33 байгууллага, 29 заал, 24 биеийн тамирын гадаа талбай, цол зэрэгтэй 280 тамирчин бүртгэдээд байна.

Аймагтаа анх удаа “Волейболын лиг-2018” тэмцээнийг Ноёд констракшин, Хомын тал ХХК, Улиастай сумын Засаг даргын Тамгын газар ивээн тэтгэж зохион байгуулж 6 багийн 150 тамирчин оролцож, тэмцээн 14 хоногийн хугацаанд үргэлжилж үзэгч олонтой, шударга, өрсөлдөөн ихтэй, тамирчдын ур чадварыг харуулсан сайхан тэмцээн болж өндөрлөлөө. Эрэгтэй төрөлд Буянзаяа дасгалжуулагчтай Зэвсэгт хүчний 325-р анги, Ц.Мөнхцэцэг дасгалжуулагчтай Жавхлант цогцолбор сургууль, Б.Эрдэнэбаатар дасгалжуулагчтай Улиастай сум Эмэгтэй төрөлд Ц.Мөнхцэцэг дасгалжуулагчтай Жавхлант цогцолбор сургууль, Т.Бат-эрдэнэ дасгалжуулагчтай Чандмана-эрдэнэ лаборари сургууль тэргүүлж оролцсон байна.

Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан “Бүсийн боксын нээлттэй тэмцээн”-нд аймгийн баг тамирчид оролцож 2 мөнгө 3 хүрэл медаль хүртлээ.

Өсвөрийн шатарчдын аймгийн аварга шалгаруулах “Цодгор хүү” 2018 тэмцээнийг 3 насны ангиллаар зохион байгуулж улсын тэмцээнд оролцох аваргуудаа тодруулан шагнаж урамшууллаа. Тэмцээнд Улиастай сумын Дэвшил ,Жавхлант ерөнхий боловсролын сургууль, Тосонцэнгэл сумын II ерөнхий боловсролын сургууль, Чандмань-эрдэнэ үндэсний лаборари сургуулиуд тэргүүлэн оролцлоо.

Нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээг эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын 2017 оны А/28 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороо хамтран “Цасны өдөрлөг”-ийг зохион байгууллаа. Цасны өдөрлөгт цасан урлал, олс таталт, уулын оргил булаалдах зэрэг

тэмцээнийг явуулж 500 гаруй иргэд оролцон тэргүүлсэн баг, иргэдэд мөнгөн шагнал өргөмжлөл олгосон байна.

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Аймгийн хэмжээгээр нийгмийн даатгалын сангаас 2017 онд 10.1 мянган хүнд 39.1 тэр бум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 15.8 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Энэ онд 11010 хүн нийгмийн даатгалд хамрагдсаны 7172 буюу 65.1 хувь нь төсөвт байгууллага, ААНэгж байгууллагын даатгуулагч, 3838 иргэн буюу 34.9 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан байна.

Сангуудаар авч үзвэл: тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 2.9 хувиар, ҮОМШӨ сангийн орлогын төлөвлөгөөг 20.6 хувиар давуулан биелүүлж, тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 5.0 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 2.2 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 8.4 хувиар тус тус тасарсан байна.

Тэтгэвэрийн сангийн зарлага 32630.3 сая төгрөг, Тэтгэмжийн сангийн зарлага 1312.7 сая төгрөг, Эрүүл мэндийн сангийн зарлага 4447.2 сая төгрөг, ҮОМШӨ-ний зарлага 45.1 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалийн сангаас 620.4 сая төгрөг тус тус зарцуулж нийт 39055.7 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, даатгалыг олгосон байна.

2017 онд халамжийн сангийн үйл ажиллагааны мэдээгээр Халамжийн тэтгэвэр 1780 хүнд 3224.9 сая төгрөг, нөхцөлд мөнгөн тэтгэмж 9950 хүнд 3110.2 сая төгрөг, нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт 13384 хүнд 2036.3 сая төгрөг нийт 25114 хүнд 8371.4 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийг үзүүлсэн байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд: Мал сүргийн тоо толгой: 2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 3597.3 мянган толгой мал үүнээс 1444.8 мянган хээлтэгч тоологдож, өнгөрсөн оноос нийт малын тоо 191.1 (5.6%) мянга, тэмээ 0.6 (8.2%) мянга, адуу 21.3 (11.4%) мянга, үхэр 19.8 (11.5%) мянга, хонь 107.5 (6.2%) мянга, ямаа 41.9 (3.2%) мянган толгойгоор тус тус өссөн байна.

Нийт тоологдсон малын тоогоор Алдархаан сум 296.7 мянган толгой мал, 152.3 мянган ямаагаар, Их-Уул сум 17.1 мянган адуу, 26.9 мянган үхэр, 146.4 мянган хониор, Дөрвөлжин сум 2.2 мянган тэмээгээр тус тус тэргүүлж, мянгаас дээш малтай өрх 662 боллоо.

Нийт малын тоо

	/мянган толгой/									
	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Тэмээ	6.6	6.6	5.8	6.2	6.3	6.3	6.5	6.7	6.9	7.5
Адуу	129.4	124.0	93.4	105.4	116.8	130.1	147.4	163.1	186.2	207.4
Үхэр	149.8	137.4	73.7	83.3	98.3	115.3	138.9	158.9	172.4	192.2

Хонь	1554.6	1462.0	859.1	979.6	1147.9	1280.0	1464.4	1562.6	1730.2	1837.7
Ямаа	1295.6	1097.6	685.7	831.6	910.7	1007.3	1138.6	1241.7	1310.5	1352.5
Дүн	3136.0	2827.6	1717.7	2006.1	2280.0	2539.0	2895.9	3133.0	3406.2	3597.3
Улсын дүнд эзлэх хувь	7.2	6.5	5.2	5.5	5.6	5.6	5.6	5.6	5.5	5.4



Малаараа тэргүүлсэн сум

Малын төрөл	Бүх малаар	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Сумын нэр	Алдархаан	Дөрвөлжин	Их-Уул	Их-Уул	Их-Уул	Алдархаан
Малын тоо	296696	2235	17148	26864	146375	152325

Малаараа тэргүүлсэн баг

	Бүх малаар	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Сумын нэр	Алдархаан	Дөрвөлжин	Сантмаргаз	Их-Уул	Их-Уул	Алдархаан
Багийн нэр	Өгөөмөр	Таван толгой	Баяннуур	Зарт	Хуягт	Өгөөмөр
Малын тоо	78234	823	4391	7866	41455	43719

Сүргийн бүтэц: Нийт мал сүргийн дотор тэмээ 0.2 хувь, адуу 5.8 хувь, үхэр 5.3 хувь, хонь 51.1 хувь, ямаа 37.6 хувийг эзэлж, бод мал, хонин сүргийн хувийн жин нэмэгдэж сүргийн зохистой бүтэц бүрдэж байна.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний нийт малын 29.5 хувьтай тэнцэх 1003.4 мянган малыг хэрэглээнд зарцуулсан байна. Малтай нэг өрхөд дунджаар 76 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсаныг аймгийн нийт өрхөд харьцуулвал нэг өрхөд дунджаар 47 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан тооцоо гарч байна.

Нутгийн шилдэг омог, цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн сайжруулсан үүлдрийн малын тоо: 2017 онд цэвэр үүлдэрийн үхэр 2.6 мянга, цэвэр үүлдэрийн адуу 11.2 мянга, тэс хэвшлийн адуу 8.3 мянга, шилдэг үүлдэрийн ямаа 226.4 мянга,

цэвэр үүлдэрийн сартуул хонь 502.8 мянга тус тус тоологдсон байна. **Тэжээвэр амьтад:** 69 гахай, 148 шувуу /тахиа/ тус тус тоологдлоо.

Малжуулалт : Энэ онд аймгийн дүнгээр 144 өрхийг 515.9 сая төгрөгийн 9149 толгой малаар малжуулсан байна. Малжуулах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн 48.7 хувийг орон нутгийн хөрөнгөөр, 51.3 хувь нь бусад эх үүсвэрээс санхүүжигдсэн байна.

Худаг, усан сан: Энэ онд 12 худаг шинээр гаргаж, 16 худагт засвар хийж нийт 252.7 сая төгрөг зарцуулсан байна.

Малчдын нийгэм ахуйн зарим үзүүлэлт: Малчдын нийгэм ахуйн зарим үзүүлэлтийг судлахад малчин өрхийн 90.4 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 82.2 хувь нь телевизортой, 80.2 хувь нь сансрын антентай, 59.2 хувь нь авто машинтай, 54.8 хувь нь мотоцикльтой байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

6.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Монгол улсын байгаль, цаг агаарын урьчилан сэргийлэх мэдээгээр 2017-2018 оны өвөл монгол орны нийт нутгаар олон жилийн дундажаас хүйтэн, цас их орох төлөвтэй байгаа холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасныг үндэслэн зэрлэг амьтны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, мал амьтны гоц халдварт өвчнөөс урьчилан сэргийлэх, өвчин гарсан үед шуурхай зохион байгуулж тархалтыг зогсоох зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:

2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс Их-Уул сумын Зарт багийн Халуун усны Шар ширэнгийн даваанд 3 уут хужир, Рашаантын баруун эхэнд 2 уут хужир, Цэцүүх багийн Цуйрайт 3 уут хужир, Хуягт багийн Сангийн далайн Сайхан сэвсүүл 3 уут хужир, Сангийн далайн хойд эхэнд 3 уут хужир нийт 14 уут хужир, Тосонцэнгэл сумын Оргих багийн Доод харганы даваа 5 уут хужир, Дээд харганы зоо 5 уут хужир, Рашаант багийн Хүйш 5 уут хужир, Зүүн эхийн Ноостой 5 уут хужир, Зүүн эхийн гурван хушд 5 уут хужир нийт 25 уут хужир, Тэлмэн сумын Баянтэгш багийн Гахай түмбэнд 4 уут хужир, Хосын даваанд 4 уут хужир, Нуур багийн Тэмээний ар 3 уут хужир, Асгатын ар 3 уут хужир нийт 14 уут хужир, Алдархаан сумын Ямаан усанд 3 уут хужир, Зүүн хайрханд 4 уут хужир тавьж 4 сумын хэмжээнд нийт 53 шуудай 2,5 тн хужир тавьж биотехникийн арга хэмжээ аваад байна.

Цаашид Тусгай хамгаалалттай газар нутаг болон говийн хүндэрсэн сумдад биотехникийн арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна.

2017 онд мал, зэрлэг амьтны гоц халдварт өвчин гарч монгол бөхөн, цагаан зээр өвчилж олон тоогоор хорогдсон, цаашид өвчний гаралт, тархалтыг нэмэгдүүлэхгүй байх зорилгоор Байгаль хамгаалагч, БОХУБайцаагч нарт мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, иргэд олон нийтэд бог малын мялзан өвчнийг таних, тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлага тараан сурталчилж байна.

“Ус” дэд хөтөлбөрийн хоёрдугаар үе шатны 2018-2021он хүртэл хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар 1 дүгээр улиралд багтаан хэлэлцүүлэн батлуулхаар төлөвлөн хамтран хэрэгжүүлэх байгууллага болох Хүнс хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Амь-Ус трейд ХХК, Ус, цаг уур орчны шинжилгээний газруудаас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг нэгтгэн авхаар албан тоотыг 2018.01.15ны өдөр хүргүүлээд байна.

ХНЗГСГЗ-ны мэргэжилтэнүүдтэй хамтран “Усалгаатай газар тариалан эрхэлэгч болон ШТС, дулаан үйлвэрлэгч аж ахуй нэгж байгууллагуудад усны хууль тогтоомж танилцуулах ажлын төлөвлөгөө боловсруулж 2018.01.19-ны өдөр Улиастай сумын онцгой хамгаалалтын бүсэд байрлан үйл ажиллагаагаа явуулж байгаа ШТС-уудаар Усны тухай болон түүнд нийцүүлэн гаргасан БОНХАЖ-ын сайд, БХБ-ын сайдын хамтарсан 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А-230/127 тушаалыг танилцуулах, хэрэгжилтийг хангуулах талаар санал солилцож гарын авлагыг тараалаа.

Тосонцэнгэл сумд үйл ажиллагаа явуулж байгаа “Зулзган мод төгөл” ХХК, “Хосын гол өлзийт” ХХК, “Анын агуйт” ХХК, “Ойн их хишиг” ХХК, “Жанчивсэмбаа” ХХК, Идэр сумд үйл ажиллагаа явуулж байгаа “Баянтэгш баяжих” ХХК, Их-Уул сумд үйл ажиллагаа явуулж байгаа “Рашаантын цагаан гэрүүд” ХХК-ны ойд арчилгаа цэвэрлэгээ хийх, мод модон материал бэлтгэх төсөлд, Тосонцэнгэл сумд үйл ажиллагаа явуулж байгаа “Хожуулын гол” жуулчны баазын төсөлд байгаль орчны ерөнхий үнэлгээ хийсэн.

Завхан аймгийн ашигт малтмалын орд бүхий сумдад 2018 оны 01 дүгээр сарын 20-21-нд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга А.Энхбат, Завхан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажилласан. Ажлын хэсэг Завхан аймгийн Ургамал сумын Улаан толгой багт ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа “Форс голд майнинг” ХХК, Дөрвөлжин сумын Бүчигтий, Балбархай, Бухын толгой гэдэг газруудад гар аргаар ашигт малтмал олборлогчид ирж хууль бусаар алт хайх газар малтах үйл ажиллагаа явуулж газрын хөрс, газрын хэвлийг эвдрэлд оруулсан байдлыг газар дээр нь ирж үзэн ажилласан. Дөрвөлжин сумд ашигт малтмалын

ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа уурхай болох “Баян Айраг Эксплорэйшн” ХХК-ны үйл ажиллагаатай танилцсан.

Монгол орны UN-REDD+ үндэсний хөтөлбөрөөс санхүүжүүлэн “Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаа ба уур амьсгалын өөрчлөлт” сэдэвт сургалтыг Тсонцэнгэл суманд 2018 оны 01-р сарын 03-наас 3 хоног зохион байгууллаа. Уг сургалтанд Байгаль хамгаалагч, ойн мэргэжлийн аж ахуй нэгжүүд, нөхөрлөлүүд, иргэдийг хамарсан 40 хүн оролцсон.

6.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр: Аймгийн 2017 оны аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 13тэрбум 382.2 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 20.2 хувиар буюу 2 тэрбум 701.9 сая төгрөгөөр өссөн нийт үйлдвэрлэлээс ААНэгжийн үйлдвэрлэл нь 7тэрбум 266.6 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 6 тэрбум 115.6 сая төгрөг болсон байна. Үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 43.1 хувийг, хүнсний үйлдвэрлэл 32.8 хувь, хувцас үйлдвэрлэл 12.4 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 8.7 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.6 хувь, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.2 хувь, барилгын ханын материал үйлдвэрлэл 1.0 хувь, вакум цонх үйлдвэрлэл 0.5 хувь, бусад үйлдвэрлэл 0.7 хувийг тус тус эзэлж байна.

6.3. Дэд бүтцийн чиглэлээр: 2017 онд барилгын салбарын мэдээнд барилга угсралт, их засвар, бүтээн байгуулалтын ажилд аймгийн дүнгээр 1 0 4 тэр бум 9 7 1 . 2 сая төгрөгийн ажил гүйцэтгэснийг салбараар үзвэл: Орон сууцны барилга 544.4 сая төгрөг, орон сууцны бус барилга 6 тэрбум 653.0 сая төгрөг, боловсрол соёлын салбарын бүтээн байгуулалтын 5 тэр бум 3 3 3 . 0 сая төгрөг, авто замын ажил 96 тэрбум 250.4 сая төгрөг, бусад 1 тэрбум 320.0 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг гүйцэтгэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад барилга угсралт, их засварын ажил 4.4 дахин өссөн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгүүдэд ажиллаж бүх сумдуудад 2018 онд хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудыг газар дээр нь үзэж газрын байршлыг тогтоох, тоо хэмжээ гаргах, техникийн нөхцөл бүрдүүлэх, зураг төсөв хийлгэх ажлуудын жагсаалт гаргаж төлөвлөгөө гарган ажиллаж байна. Сумдуудад хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудтай танилцаж барилга байгууламжийн судалгааг баяжуулах, эрэмбэлэх ажил хийгдэж байна.

Улсын төвлөрсөн төсөв, аймгийн үндсэн чиглэлд батлагдсан барилга хот байгуулалтын чиглэлээр тусгагдсан ажлуудын жагсаалт гаргаж зураг төсөв хийлгэх ажлыг зохион байгуулж байна.

Санмаргаз сумын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрны барилга, Дөрвөлжин, Тосонцэнгэл сумын сум дундын цагдаагийн хэлтсийн барилга, Шилүүстэй

сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Сонгино сумын эрүүл мэндийн төвийн барилга, Их-Уул, Тэс сумын Засаг даргын Тамгын газрын барилга зэрэг шинээр баригдах барилга угсралтын ажлуудын зураг төсөв хийгдсэн. Улсын төсөвт хөрөнгө батлагдсан Алдархаан сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Их-Уул сумын 300 хүний суудалтай Соёлын төвийн барилга, Ургамал сумын Засаг даргын Тамгын газрын барилгын зураг төсөв, ГХБХБГ-ын конторын барилгын их засварын ажлын зураг төсөв хийлгэх ажлыг зохион байгуулж байна.

Дунд хугацааны зорилтод хөтөлбөрийн хүрээнд 2019 онд хийгдэхээр төлөвлөж байгаа Улиастай сумын 9-р цэцэрлэгийн барилга, 4-р сургуулийн 640 хүүхдийн хичээлийн байр, Хомын тал ХХК-ны 40 айлын орон сууцны барилга, Ургамал сумын Засаг даргын Тамгын газрын барилга, сургуулийн барилга, Тосонцэнгэл сумын 2-р сургуулийн хичээлийн байрны барилгын инженер геологийн судалгаа, дүгнэлт гаргах ажлыг Инжгеотех ХХК-аар хийлгүүлж байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг Улиастай сумд баригдах дулааны цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг Эрчим хүчний яамны мэргэжилтнүүд, Солонгос улсын мэргэжилтнүүдтэй хамтран газар дээр нь ажиллаж судалгааны ажил хийгдэж байна.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР